



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№89 /533/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.06.01

Цаг үе, үйл явдал

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ АЖИЛТАН, ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫНХАА ЭНХРИЙ БЯЦХАН ҮРСТ ХҮҮХДИЙН БАЯРЫН БЭЛЭГ ГАРДУУЛАВ



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
29	8

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	29

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,445	3,460
EUR	3,778	3,801
CNY	498	501
RUB	43	43.90
JPY	26	26,10
KRW	2.59	2.62

ЗУРХАЙ



2023.06.01 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 12

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН
МОГОЙ САР
НАЙМАН ЦАГААН
ЦАГААН БАР ӨДӨР**

Үс засуулбал:

Өвчин эмгэг ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

04.58-20.42

Барилдлага:

Хотол чуулган

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Нэр өнгө

ЭНХИЙГ САХИУЛАГЧ ЭМЭГТЭЙ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДЫНХАА ҮР ХҮҮХДҮҮД ЗОРИУЛСАН АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



БХЯ, ЗХЖШ, ЦДБЭЧ, Монгол цэргийн нэгдсэн холбоо, түүний дэргэдэх “Зэв” залуучуудын клуб хамтран “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан Монгол Улсын Зэвсэгт хүчнээс БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай “UN-IMISS” энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын хүүхдүүдэд зориулсан хүндэтгэлийн концертыг зохион байгууллаа.

Арга хэмжээг нээж ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах хэлсэн үгэндээ Даян дэлхийд энхийг сахиулах эрхэм үүргийг гүйцэтгэж буй Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн эмэгтэй цэргийн алба хаагчдадаа чин сэтгэлийн талархал илэрхийлж үүргээ нэр төртэйгөөр биелүүлэн эх орон, элгэн нутаг, энхрий бяцхан үрс, хайрт хань, халуун дулаан гэр бүлдээ эргэн ирэхийн ерөөлийг өргөн дэвшүүлсэн юм.

Үргэлжлүүлэн хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад ЗХЖШ, КАБЦК, ЗТЯ-ны удирдлагууд хүүхдийн баярын бэлгийг гардуулсан бол ЦДБЭЧ, БЗД-ийн Жанжин клубийн уран бүтээлчид болон МУК-ын Бүжиг, циркийн мэргэжлийн сургуулийн сурагчид урлагийн тоглолтоо өргөн барилаа.

Мөн энэ үеэр энхрийн бяцхан үрстэйгээ алс, хол харь хүний нутагт үүрэг гүйцэтгэж буй энхийг сахиулагч ээж нар нь цахимаар холбогдож мэндчилгээ дэвшүүлсэн юм.

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Эл өдөр андгай тангаргаас няцах, дайсныг номхруулах үйлд сайн. /муу найз нөхрөөс холдож салахад ээлтэй өдөр/, сүм, суварга барих, хүүрийн газар эргэх, чуулан үймэхэд сайн. Нүд татваас эцэг эхэд аюул болох, баруун чих хангинавал эхнэртэй учрах, зүүн нь бол идээ ундаа олдох, нохой уливал гэнэт зочид ирэх болой. Энэ өдөр өндөр язгуурт хүний хэл ам болох, тагнай загатнавал их хүн ирэх, бие татвал хэрүүл тэмцэл болох, хөл татвал сайн.



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 688,380,012

Эдгэрсэн

Нийт: 660,813,456

Нас барсан

Нийт: 6,874,841

Цахим шууданд

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН...



Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын мандаттай "UNMISS" энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын санаачилгаар 5 дугаар сарын 31-ний өдөр тус улсын нийслэл Жуба хотын "Грийнсуд" бага сургуулийн 100 орчим хүүхдүүдийг оролцуулсан хүүхдийн баярын арга хэмжээг зохион байгууллаа.

"UNMISS" ажиллагаанд Зэвсэгт хүчнээс үүрэг гүйцэтгэж буй штабын офицер, ахлагч,

ажиглагч офицеруудаас эмэгтэй цэргийн алба хаагчдын санаачилгыг талархан дэмжиж, бага сургуулийн сурагчдад хэрэгцээтэй байгаа дэвтэр, үзэг, бал, харандаа, гар бөмбөг болон хөл бөмбөг зэрэг хэрэгцээт зүйлээр тусламж үзүүлсэн юм. Хүүхдийн баярын арга хэмжээг нээж "Грийнсуд" сургуулийн захирал Алев Гаранг Алев хэлсэн үгэндээ тус бага сургуульд Хүчний штаб байрлаж буй баазын дэргэд байрлах энгийн иргэдийг хамгаалах хуарангаас олон тооны хүүхдүүд суралцдаг тул Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчдаас үзүүлж буй тусламжийг тэдгээр хүүхдүүдэд хүргэхээ илэрхийлэв.

Мөн энэ үеэр "UNMISS" ажиллагааны Үндэсний ахлах төлөөлөгч хурандаа Ш.Амарбаясгалан "UNMISS" ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй нийт бүрэлдэхүүнээ төлөөлөн сургуулийн сурагчдад баярын мэндчилгээ дэвшүүлж, Монгол Улс, Зэвсэгт хүчний тухай товч танилцуулга хийсэн юм. Түүнчлэн арга хэмжээний үеэр хүүхдүүдийн дунд 2 төрлийн хөгжөөнт тоглоомыг зохион байгуулж, сурагчдын хэрэгцээнд зориулан бэлтгэсэн хичээлийн хэрэгсэл, бөмбөг зэргийг гардуулан өгөв.



44 БАЙЛДАГЧ "В" АНГИЛЛЫН ЖОЛООЧ БОЛЛОО



Зэвсэгт хүчний Тээврийн хяналтын алба нь Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Техникийн бага мэргэжилтэн бэлтгэх төв, ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвтэй хамтран ЗХЖШ-ын даргын тушаалын дагуу хугацаат цэргийн алба хаагчдад Замын хөдөлгөөний дүрмийн мэдлэг олгож, алба хаах хугацаанд нь "В" үндсэн ангиллын жолооч бэлтгэх дамжааны сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн 54 хугацаат цэргийн алба хаагч хамрагдсанаас 44 хугацаат цэргийн алба хаагч "Замын хөдөлгөөний дүрэм"-ийн болон жолоодлогын шалгалтад тэнцэж "В" ангиллын тээврийн хэрэгсэл жолоодох эрхтэй болов.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТЭЭВРИЙН ХЯНАЛТЫН АЛБА

БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАР "ШҮГЭЛ" АЖИЛЛАГАА-НД МАНЛАЙЛАН ОРОЛЦОЖ БАЙНА



Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар "2023-2024 оныг Авлигатай тэмцэх жил болгон зарлах тухай" 49 дүгээр тогтоолыг баталсан. Тус тогтоолын хүрээнд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй "Авлигатай тэмцэх 5 Ш үйл ажиллагаа"-ны нэг болох "Шүгэл" ажиллагааны талаарх аяныг Авлигатай тэмцэх газраас 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн зохион байгуулж буй.

Тус аяныг батлан хамгаалах салбар идэвх санаачилгатай дэмжиж, манлайлан оролцож байна. Энэ хүрээнд Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён

гэгээрүүлэх хэлтэстэй хамтран "Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл" ТӨААТҮГ-аас "Гэр бүлийн төлөө нэгдье", "Авлигын эсрэг нэгдье" үйл ажиллагааг 6 дугаар сарын 1-ний өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд амжилттай зохион байгуулсан юм. Мөн Зэвсэгт хүчний 084, 124 дүгээр ангийн хамт олон "Авлигын эсрэг нэгдье, бид хамтдаа" шторч бүтээж, "Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг зохион байгууллаа.

Тэгвэл энэ сарын 3-ны өдөр "Олон улсын марафон гүйлт" болон "Авлигын эсрэг нэгдье" үйл ажиллагааг сурталчлах аянд ҮБХИС-ийн 100 гаруй оюутан, сонсогч оролцож юм.

АХЛАХ АХЛАГЧ Э.ДАВААЖАМЦ "УЛААНБААТАР МАРАФОН-2023"-Д ОРОЛЦОНО



"Улаанбаатар марафон" олон улсын гүйлтийн тэмцээн маргааш буюу 6 дугаар сарын 3-ны өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдана.

Монгол Улсад гүйлтийн спортыг хөгжүүлэх, гүйлтээр хичээллэгч, сонирхогч иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр, залуу үеийнхэнд бие бялдар, оюун санааны өв тэгш хүмүүжлийг төлөвшүүлэх зорилгоор "Улаанбаатар

марафон" олон улсын гүйлтийн тэмцээнийг 2014 оноос уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн юм.

Энэ жил тус тэмцээнийг өдөрлөг хэлбэрээр НЗДТГ, Нийслэлийн биеийн тамир, спортын газар, "Хай пэймэнт солишнс" ХХК /Hipay/, Монголын хөнгөн атлетийн холбоо хамтран автомашингүй өдрөөр зохион байгуулж байгаа бөгөөд тэмцээн өнгөрсөн жилүүдийн адил 1500 метр, 5000 метр, 10 км, 21 км, 42 км гэсэн гүйлтийн ангилалтай.

Гүйгчдийн дунд Зэвсэгт хүчний мэргэжлийн болон сонирхон хичээллэдэг олон алба хаагч багтсаны нэг нь Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн хөгжимчин, Монгол Улсын олон өдрийн ганцаарчилсан гүйлтийн рекорд эзэмшигч, спортын мастер, ахлах ахлагч Э.Даваажамц ажээ.

Тэрээр энэ өдөр хамгийн холыг зайг буюу 42 км замыг цэргийн дүрэмт хувцастайгаа туулахаар төлөвлөжээ. Энэ тухайгаа ярихдаа "Олон улсын тэмцээн учраас дэлхийн болоод манай улсын мэргэжлийн шилдэг тамирчид оролцоно. Миний хувьд түрүүлэхдээ биш оролцох нь чухал гэж үзээд холбогдох зөвшөөрлөө ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрынхнаас аваад гүйч бэлтгэлээ хангаж байна" гэсэн хариулт өгсөн юм.

СУРАГЧДАД ЦЭРГИЙН АЛБЫГ СУРТАЛЧИЛЛАА



"Олон улсын нарынхаа ажлын орчинтой хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг угтан Төв аймгийн Зуунмод сумын Ерөнхий боловсролын IV сургуулийн ахлах ангийн сурагчид болон дотуур байрны хүүхдүүд Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалд зочилж, цэргийн ах эгч

байдаг бөгөөд энэ удаа ахлах ангийн сурагчдыг түлхүү хамруулснаараа онцлог юм. Энэ үеэр сурагчид "2016 онд "Хааны эрэлд" олон улсын энхийг дэмжих сургуулийн хүрээнд алслагдмал сумдын багачууд бидэнд бүх зүйл нь нэг дороо төвлөрсөн дотуур байр барьж өгсөн цэргийн ах, эгч нартаа баярладаг" хэмээн талархал илэрхийлж, өнгөрсөн 7 жилийн хугацаанд Төв аймгийн 16 сумын олон зуун багачууд энэ л дотуур байранд амьдарч, зарим нь эхнээсээ оюутан болсон тухай тодотгож байлаа. Сурагчид командлалын "Алдрын танхим", "Номын сан", "Хурлын танхим", "Бялдаржуулах танхим"-аар тус тус зочилж, цэргийн албаны талаар эерэг мэдээлэл авсандаа ихэд олзуурхаж, баяртайгаар буцлаа.



ЭНХИЙГ САХИУЛАГЧДАА АЛДАРШУУЛАВ



Зэвсэгт хүчний 339 дүгээр анги нь Монгол Улсын Зэвсэгт хүчин энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 21 жилийн ойн хүрээнд цэргийн тангараг давтах хүндэтгэлийн ажиллагааг Баянхонгор аймгийн "Баганат" талбайд зохион байгууллаа. Хүндэтгэлийн ажиллагаанд Баянхонгор аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Г.Нэмэхбаяр, хууль зүйн хэлтсийн дарга Д.Сарангарав, Цагдаагийн газрын дарга цагдаагийн дэд хурандаа Б.Мөнхбаяр төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын бие

бүрэлдэхүүн оролцов.

Энэ үеэр НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдад дурсгалын зүйл гардуулав. Ташрамд дуулгахад энэ сарын 26-ны өдөр эл тэмдэглэлт өдрийг угтан Баянхонгор аймгийн Баян-Овоо, Эрдэнэцогт сумын ард иргэд, хүүхэд залууст энхийг сахиулагчдынхаа ололт, алдар гавьяаг алдаршуулан сурталчилж, иргэд хүүхэд залуус, өсвөр үеийнхэнд даян дэлхий энх тайван, тогтвортой байхын ач холбогдлыг таниулах ажлыг зохион байгуулсан юм.